



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/131

Улаанбаатар хот

Сэрэмжлүүлэг шторк хийх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цаг үеийн болон гамшгийн нөхцөл байдалтай уялдуулан тус бүр 15 секундийн үргэлжлэх хугацаатай хог, хогийн сувгийн гал түймрээс болон халтиргаа гулгаанаас үүдэлтэй гэмтэл ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг зөвлөмж бүхий анимейшн видео шторкуудыг мэргэжлийн байгууллагаар хийлгэсүгэй.

2. Хоёр төрлийн анимейшн видео шторкийг хариуцан хийлгэхийг Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс (хурандаа Г.Нэргүй)-т даалгасугай.

3. Гал түймэр, гэмтэл ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмж бүхий анимейшн видео шторкуудыг хийлгэх зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

4. Анимейшн видео шторкуудыг хийлгэхэд шаардагдах 4.130.000 (Дөрвөн сая нэг зуун гучин мянган) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гал түймэртэй тэмцэх, гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан Тэргүүн дэд дарга (хурандаа Н.Нямхорлоо)-т даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА  Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



D:/My documents-blank-2019-tushaal

00115050 06

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн
А/151 дугаар тушаалын хавсралт



ГАЛ ТҮЙМЭР, ГЭМТЭЛ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АНИМЕЙШН ВИДЕО ШТОРКУУД ХИЙЛГЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Зардлын нэр		Хэмжих нэгж	Нэгжийн үнэ /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт /төгрөг/
1	3D хэмжээст анимейшн хий	Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх шторк	ш	2.030.000	1	2.030.000
3		Гэмтэл ослоос урьдчилан сэргийлэх шторк	ш	2.100.000	1	2.100.000
Нийт				4.130.000		